



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/51/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор  
2023 оны 02 дугаар сарын 17

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)  
Аудитын менежер: А.Цээням  
Утас: 70442424 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)  
Аудитор: Н.Батчимэг  
Утас: 91113253 Цахим хаяг: [batchimegn@audit.gov.mn](mailto:batchimegn@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584  
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

Г ГУРВАНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ Г  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН Г  
ЗАХИРАЛ Д.ЦЭЦЭГЭЭ ТАНАА Г

2023.02.17 № 2/62  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан, Бүгд найрамдах Солонгос улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага KOICA-ийн дэмжлэгээр хийгдсэн 168,699.5 мянган төгрөгийн үнэ бүхий дотуур байрны ариун цэврийн өрөөний өргөтгөл ашиглалтад орж тайландаа бүртгэж тайлагнасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль

025020284

нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилт, 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Боловсрол шинжлэх ухааны газраас 96.7 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style, starting from the left and extending towards the right, crossing the stamp.

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>113,395,002.81</u></b>	<b><u>126,916,214.06</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	4,800,867.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	4,800,867.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	4,800,867.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	4,800,867.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3,789,856.03	572,213.24
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,217,642.79	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	572,213.24	572,213.24
3351	Байгууллагаас авах авлага	572,213.24	572,213.24
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	109,605,146.78	121,543,133.82
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	39,161,225.38	60,087,144.82
35110	Тусгай зориулалттай материал	33,867,225.38	55,163,344.82
35130	Эм боох материал	5,294,000.00	4,923,800.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	62,013,921.40	52,785,989.00
35410	Бичиг хэргийн материал	3,450,152.00	6,690,552.00
35420	Аж ахуйн материал	42,647,969.40	30,179,637.00
35470	Бусад хангамжийн материал	15,915,800.00	15,915,800.00
35600	Мал амьтад	8,430,000.00	8,670,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,224,978,141.89</u></b>	<b><u>1,363,087,807.13</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,224,978,141.89	1,363,087,807.13
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,194,118,141.90	1,332,237,807.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,267,648,720.00	1,427,640,851.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-206,429,075.88	-272,582,262.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	199,222,865.53	211,745,024.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-129,183,378.41	-113,533,070.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	114,271,870.78	139,421,870.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	-58,944,776.32	-67,986,522.33
39217	Ном	7,531,916.20	7,531,916.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	30,859,999.99	30,850,000.00
39301	Программ хангамж	320,000.00	320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-310,000.01	-320,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30,850,000.00	30,850,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,338,373,144.70</u></b>	<b><u>1,490,004,021.19</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>759,300.92</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	759,300.92
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	759,300.92
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	759,300.92
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,338,373,144.70</u></b>	<b><u>1,489,244,720.27</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,338,373,144.70	1,489,244,720.27

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	767,534,111.81	767,534,111.81
51101	Өмч: - төрийн	767,534,111.81	767,534,111.81
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	93,392,874.62	244,264,450.19
51210	Өмнөх үеийн үр дүн	93,392,874.62	93,392,874.62
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	150,871,575.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	477,446,158.27	477,446,158.27
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,338,373,144.70</u></b>	<b><u>1,490,004,021.19</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<b>830,052,072.74</b>	<b>1,201,498,311.84</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<b>17,185,765.00</b>	<b>257,662,011.84</b>
120	Нийтлэг татварын бус орлого	11,870,765.00	34,032,644.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,177,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,177,200.00
121	Хөрөнгийн орлого	5,315,000.00	223,629,367.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<b>92,451,207.74</b>	<b>943,836,300.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	823,039,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	823,039,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	720,415,100.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,959,032.00	800,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,309,032.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	650,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,492,175.74	119,996,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,492,175.74	119,996,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<b>909,677,203.87</b>	<b>1,050,626,736.27</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>909,677,203.87</b>	<b>1,050,626,736.27</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	824,394,188.91	1,043,170,146.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	538,751,742.82	646,076,720.27
210101	Үндсэн цалин	538,751,742.82	459,482,797.81
210102	Нэмэгдэл	00.00	133,962,065.84
210104	Урамшуулал	00.00	22,977,857.86
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	29,653,998.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,974,697.00	82,094,847.75
210201	Тэтгэврийн даатгал	49,143,224.00	56,289,658.04
210202	Тэтгэмжийн даатгал	5,405,317.00	6,438,982.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,324,254.00	5,504,038.94
210204	Ажилгүйдлийн даатгал	1,009,264.00	1,253,719.34

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210205	Эрүүл мэндийн даатгал	10,092,638.00	12,608,448.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>71,913,775.74</b>	<b>79,455,678.97</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,651,900.74	6,170,878.97
210302	Түлш, халаалт	67,472,625.00	72,004,550.00
210303	Цэвэр, бохир ус	789,250.00	1,280,250.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,665,625.00</b>	<b>40,620,927.10</b>
210401	Бичиг хэрэг	6,698,060.00	6,502,880.00
210402	Тээвэр, шатахуун	1,538,500.00	3,389,989.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	491,800.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,787,265.00	5,010,700.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	25,717,357.40
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>19,115,295.00</b>	<b>83,668,030.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,674,595.00	609,000.00
210502	Хоол, хүнс	13,440,700.00	83,059,030.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,980,320.00</b>	<b>750,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	902,920.00	00.00
210604	Урсгал засвар	1,077,400.00	750,000.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>464,700.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилот	464,700.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,600,950.00</b>	<b>5,708,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,100,950.00	1,977,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	3,731,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>103,927,083.35</b>	<b>104,795,742.16</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	8,643,040.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	344,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	103,927,083.35	95,808,702.16
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>85,283,014.96</b>	<b>7,456,590.02</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>39,254,288.00</b>	<b>00.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,123,300.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	19,130,988.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>178,044.00</b>	<b>7,456,590.02</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>45,850,682.96</b>	<b>00.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,850,682.96	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-79,625,131.13</u></b>	<b><u>150,871,575.57</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>8,630,000.00</b>	<b>00.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	8,630,000.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-8,630,000.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-88,255,131.13</u></b>	<b><u>150,871,575.57</u></b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>812,966,307.74</u></b>	<b><u>945,013,500.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>1,177,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	1,177,200.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	1,177,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,177,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>812,966,307.74</b>	<b>943,836,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	823,039,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	823,039,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	720,515,100.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	19,959,032.00	800,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,309,032.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	650,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	72,492,175.74	119,996,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,492,175.74	119,996,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>809,430,407.74</u></b>	<b><u>929,923,633.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>809,430,407.74</b>	<b>929,923,633.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>724,147,392.78</b>	<b>879,391,492.98</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	528,010,292.04	644,057,985.07
210101	Үндсэн цалин	404,227,238.62	453,086,794.30
210102	Нэмэгдэл	88,780,137.95	138,987,479.90
210104	Урамшуулал	35,002,915.47	23,618,913.74
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	28,364,797.13
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	77,532,700.00	80,136,639.24
210201	Тэтгэврийн даатгал	57,780,800.00	51,039,916.05
210202	Тэтгэмжийн даатгал	4,938,000.00	10,021,041.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,950,300.00	4,842,831.62
210204	Ажилгүйдлийн даатгал	987,700.00	2,036,248.57
210205	Эрүүл мэндийн даатгал	9,875,900.00	12,196,601.57
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	72,032,275.74	79,455,678.97
210301	Гэрэл, цахилгаан	3,651,900.74	6,170,878.97
210302	Түлш, халаалт	67,472,625.00	72,004,550.00

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210303	Цэвэр, бохир ус	907,750.00	1,280,250.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,865,340.00	00.00
210401	Бичиг хэрэг	954,600.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,538,500.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,719,040.00	00.00
210404	Ном, хэвлэл	43,200.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,460,000.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	28,636,215.00	39,983,480.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,323,595.00	00.00
210502	Хоол, хүнс	13,440,700.00	39,983,480.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,871,920.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,057,900.00	1,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	00.00
210602	Тавилга	396,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,861,900.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	464,700.00	00.00
210702	Дотоод албан томилолт	464,700.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,094,950.00	7,782,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,354,950.00	1,977,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	5,805,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,453,020.00	26,975,009.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	18,262,874.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,453,020.00	8,712,135.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>85,283,014.96</b>	<b>50,532,140.02</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	39,254,288.00	43,075,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,123,300.00	43,075,550.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	19,130,988.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	178,044.00	7,456,590.02
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	45,850,682.96	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,850,682.96	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>3,535,900.00</u></b>	<b><u>15,089,867.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,535,900.00</b>	<b>10,289,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,535,900.00</b>	<b>10,289,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	3,535,900.00	10,289,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,535,900.00	10,289,000.00

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-3,535,900.00</u></b>	<b><u>-10,289,000.00</u></b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	4,800,867.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	4,800,867.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	736,684,111.81	375,732,125.20	-128,686,531.08	00.00	983,729,705.93
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	736,684,111.81	375,732,125.20	-128,686,531.08	00.00	983,729,705.93
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	95,897,733.29	00.00	95,897,733.29
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	767,534,111.81	477,446,158.27	93,392,874.62	00.00	1,338,373,144.70
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	767,534,111.81	477,446,158.27	93,392,874.62	00.00	1,338,373,144.70
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	767,534,111.81	477,446,158.27	93,392,874.62	00.00	1,338,373,144.70
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	150,871,575.57	00.00	150,871,575.57
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	767,534,111.81	477,446,158.27	244,264,450.19	00.00	1,489,244,720.27

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	957,913,500.00	932,756,042.98	25,157,457.02	97.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	957,913,500.00	932,756,042.98	25,157,457.02	97.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	914,083,500.00	889,680,492.98	24,403,007.02	97.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	645,663,100.00	644,057,985.07	1,605,114.93	99.8
210101	Үндсэн цалин	473,982,700.00	453,086,794.30	20,895,905.70	95.6
210102	Нэмэгдэл	129,022,700.00	138,987,479.90	(9,964,779.90)	107.7
210104	Урамшуулал	12,795,300.00	23,618,913.74	(10,823,613.74)	184.6
210105	Гэрээт ажлын хөлс	29,862,400.00	28,364,797.13	1,497,602.87	95.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	80,708,000.00	80,136,639.24	571,360.76	99.3

**Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

	ШИМТГЭЛ				
210201	Тэтгэврийн даатгал	54,881,400.00	51,039,916.05	3,841,483.95	93.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,456,600.00	10,021,041.43	(3,564,441.43)	155.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,165,400.00	4,842,831.62	322,568.38	93.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,291,300.00	2,036,248.57	(744,948.57)	157.7
210205	Эрүүл мэндийн даатгал	12,913,300.00	12,196,601.57	716,698.43	94.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>98,301,700.00</b>	<b>79,455,678.97</b>	<b>18,846,021.03</b>	<b>80.8</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,371,800.00	6,170,878.97	200,921.03	96.8
210302	Түлш, халаалт	90,429,900.00	72,004,550.00	18,425,350.00	79.6
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,280,250.00	219,750.00	85.4
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>43,077,900.00</b>	<b>39,983,480.00</b>	<b>3,094,420.00</b>	<b>92.8</b>
210502	Хоол, хүнс	43,077,900.00	39,983,480.00	3,094,420.00	92.8
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,785,800.00</b>	<b>7,782,700.00</b>	<b>3,100.00</b>	<b>100.0</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,808,600.00	5,805,500.00	3,100.00	99.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>37,547,000.00</b>	<b>37,264,009.70</b>	<b>282,990.30</b>	<b>99.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,834,100.00	28,551,874.70	282,225.30	99.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,712,900.00	8,712,135.00	765.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>43,830,000.00</b>	<b>43,075,550.00</b>	<b>754,450.00</b>	<b>98.3</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>43,830,000.00</b>	<b>43,075,550.00</b>	<b>754,450.00</b>	<b>98.3</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,830,000.00	43,075,550.00	754,450.00	98.3
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>958,378,500.00</b>	<b>937,556,909.98</b>	<b>20,821,590.02</b>	<b>97.8</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>132,896,800.00</b>	<b>112,540,209.98</b>	<b>20,356,590.02</b>	<b>84.7</b>
132001	Орон нутгийн төсвөөс	132,896,800.00	112,540,209.98	20,356,590.02	84.7
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,642,200.00</b>	<b>1,177,200.00</b>	<b>465,000.00</b>	<b>71.7</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,642,200.00	1,177,200.00	465,000.00	71.7
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>4,800,867.00</b>	<b>(4,800,867.00)</b>	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Тус байгууллага нь Боловсролын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг, сурагчдад суурь боловсрол олгож, мэргэжлийн багш нар сургалтын үйл ажиллагааг явуулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, ил тод хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Боловсрол шинжлэх ухааны харьяа байгууллага юм.

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд нийт 47 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж, нийт 17 бүлэг, 356 сурагчтай, 2022 оны үйл ажиллагааны зардалд 824,681.7 мянган төгрөг батлагдсан байна.

Гурванбулаг сумын ЕБС-ийн зорилго, зорилт: “Бид хурдацтай өөрчлөгдөж буй нийгэмд дасан зохицох чадвартай, зорилго тэмүүлэлтэй, тасралтгүй суралцах иргэдийг төлөвшүүлнэ”, мөн байгууллагын эрх зүйн орчныг боловсронгуй болгон үйл ажиллагааг цахимжуулах, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, удирдлагын манлайллыг дээшлүүлэхэд оршино.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг захирал Д.Цэцгээ, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Дорждагва (2022.01.01-2022.02.12), О.Бямбасүрэн (2022.02.12-2022.03.20), Б.Шүрсайхан (2022.03.20-2022.11.04), М.Эрдэнэтуяа (2022.11.04-2022.12.31) нар зурж, нярваар М.Эрдэнэтуяа, С.Цэцгээ нар ажиллажээ.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор цалингийн шатлал,
- Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 184 дүгээр тогтоолоор цалингийн шатлал,
- Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 192 дүгээр тогтоолоор цалингийн шатлал,
- БШУС-ын 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн А/122 тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ЕБС-ийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээ,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал
- БШУС-ын 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаал

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг Баянхонгор аймгийн төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх НББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЕБС-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,490,004.0 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 151,630.9 мянган төгрөгөөр буюу 11.3 хувиар хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	4,800.9	4,800.9
Авлага	-	572.2	572.2
Бараа материал	109,605.1	121,543.1	11,938.0
Үндсэн хөрөнгө	1,819,845.4	1,817,509.7	(2,335.7)
Хуримтлагдсан элэгдэл	(394,867.2)	(454,421.9)	(59,554.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,338,373.1</b>	<b>1,490,004.0</b>	<b>151,630.9</b>
Өр төлбөр	-	186.6	186.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,338,373.1	1,489,817.4	151,444.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1338,373.1</b>	<b>1,490,004.0</b>	<b>151,630.9</b>

Дээрх хүснэгтээс харахад, Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,800.9 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Тайлант оны эцэст хувь хүнээс авах 572.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 121,543.1 мянган төгрөг болж өмнөх оноос 11,938.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 116,981.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 11,651.1 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар, 880.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, 240.0 мянган төгрөгийн малыг тооллогоор бүртгэж, үйл ажиллагаандаа 112,181.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, хагас жилийн хөрөнгийн тооллогоор байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Захирлын 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн А/32 дугаар тушаалаар 25,717.4 мянган төгрөгийн бараа материалыг акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,817,509.7 мянган төгрөг болж 2,335.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 10,289.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 223,629.3 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, АИТХ-ын хуралдааны 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн “Хөрөнгө акталж, данснаас хасах тухай” 10/46 дугаар тогтоолоор 36,254.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталсантай тус тус холбоотой байна.

Тайлант онд ХХОАТ-ын 186.6 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 151,444.3 мянган төгрөгөөр өсөж 1,489,817.4 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 884,670.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 126,800.0 мянган төгрөг, нийт зарлагыг 1,011,470.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант хугацаанд 3 удаа тодотгол хийгдэж улсын төсвөөс 824,681.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 132,896.8 мянган төгрөг, нийт 957,578.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 824,681.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 132,896.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 824,681.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн орлогыг 132,896.8 мянган төгрөгийн санхүүжилт авч улсын төсвийн санхүүжилтийн 4,800.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвийн орлогын санхүүжилтээс 7,456.6 мянган төгрөгийг орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 931,955.8 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 12,257.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсөв					
	71802 Ерөнхий боловсрол	824,681.7	819,415.6	5,266.1	99.4
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	2,323.4	2,323.2	0.2	100.0
2	80312 Сургалт семинар	1,161.7	1,160.0	1.7	99.8
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	2,672.0	2,670.0	2.0	99.9
4	80801 Үдийн цай хөтөлбөр	43,830.0	43,075.5	754.5	98.2

**Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

5	81806 Дотуур байрны үйлчилгээ	59,844.8	56,306.1	3,538.7	93.9
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	11,990.0	11,980.2	9.8	99.9
7	81823 Боловсролын байгууллагын багш	5,227.7	4,960.0	267.7	94.9
8	81834 Боловсролыг стандарт	612,433.3	612,247.0	186.3	99.9
9	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	83,556.6	83,516.4	440.2	100.0
10	81848 Сурах бичгийн түрээс	1,642.2	1,177.2	465.0	79.2
<b>Орон нутгийн төсөв</b>					
	71802 Ерөнхий боловсрол	132,896.8	112,540.2	20,356.5	84.7
1	80112 Нийтлэг үйлчилгээ	132,896.8	112,540.2	20,356.5	84.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гурванбулаг сумын ЗДТГ-аас 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдөр тэмцээний зардалд 800.0 мянган төгрөг орсныг тус сумд зохион байгуулагдсан Хангайн бүсийн аварга шалгаруулах Жудо бөхийн тэмцээнд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 1/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 909,677.2 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 909,677.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,645.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9,551.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2022 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 18,846.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 282.2 мянга, нийт 19,128.2 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 145 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 4 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тус байгууллага нь тайлант онд 39,150.0 мянган төгрөгийн үдийн цай хөтөлбөр, 50,077.9 мянган төгрөгийн дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нийлүүлэх нийлүүлэгчийг сонгохоор харьцуулалтын аргаар тендер зарлах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаа хоцроож байршуулсан, дулаанаар хангах, хүнс болон үдийн цайны материал худалдан авах 3 гэрээний 164,985.8 мянга, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 462,094.8 мянган төгрөгийн 6 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 63,532.0 мянган төгрөгийн 8 гүйлгээ, өмч хөрөнгө, хүний нөөцтэй холбоотой 45 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 502,105.9 мянган төгрөгийн 13 гүйлгээ, зарлагын 42,995.7 мянган төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн, мэдээллийг хугацаанд нь цахим хуудаст үнэн зөв дүнгээр байршуулж буйд тавих төсвийн шууд захирагчийн хяналтыг сайжруулах.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,940.2 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрч 203.6 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгснийг биелүүлсэн, 5,736.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосноос 1 актын 3,217.6 мянган төгрөгийн төлбөр барагдаж, 1 актын 2,519.0 мянган төгрөгийн төлбөр барагдаагүй байна.

Уг актыг барагдуулахаар тус байгууллагын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Хүсэлт гаргах тухай" 105 дугаар албан бичгээр Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд "Хөгжил дэвшил нэгдэл" ХХК-ийн 2,519.0 мянган төгрөгийн төлбөрийг төлүүлэх нэхэмжлэл гаргасан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	5,736.6	1	3,217.6	56.1
Албан шаардлага	3	203.6	3	203.6	100.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>5,940.2</b>	<b>4</b>	<b>3,421.2</b>	<b>80.0</b>

Албан шаардлага, актын биелэлтийг тус газрын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 35 тоот албан бичгээр ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2001-2002 онд нярваар ажиллаж байсан Ч.Батсүхтэй холбоотой 572.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлага өгсөн ч авлага барагдаагүй байна.

Мөн Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 131/ШШ2020/00848 тоот захирамж, аймгийн засаг даргын 2020 оны А/784 тоот захирамжийн дагуу сургуулийн захирал Д.Цэцэгээд ажилгүй байсан хугацааны 4,335.2 мянган төгрөг олгосон зөрчлийг арилгаж төрд учирсан хохирлыг барагдуулах албан шаардлагыг 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд өгсөн ч хэрэгжээгүй байна.

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх"-ыг БСШУСС, Сангийн сайд болон аймаг,

нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 оны 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй, хоолны ирцэд хяналт тавьснаар дотуур байрны хүүхдийн хоолны зардал 3,094.4 мянга, Үдийн цай хөтөлбөрийн зардал 754.5 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 572.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын хэлтэст 563.7 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн боловч өр төлбөрөөр тусгаагүй, ХХОАТ-ын өглөгийг 8.9 мянган төгрөгөөр дутуу тусгасныг тус тус залруулав.

Аудитаар нийт 4,197.8 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 284.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 2,559.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,354.2 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Багшийн хөгжлийг дэмжих зардлаас Жүдо бөхийн тэмцээний зардалд багш Ш.Буян-Өлзийд замын зардалд 142.0 мянга, түүхийн улсын олимпиадын зардалд багш Д.Нацагдоржид 142.0 мянган төгрөгийг замын зардлын баримтгүй байхад шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт бусаар зарцуулсан 284.0 мянган төгрөгийн замын зардлыг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Ажиллагсдын 2022 оны 7 дугаар сарын цалинг Нийгмийн даатгалын хэлтэст 2,559.6 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх “ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын 2022 оны 2,559.6 мянган төгрөгийн цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Хичээл практикийн зардлаас шатахууны зардалд 531.8 мянган төгрөг, хулдаасан хэвлэлд 158.4 мянган төгрөг, албан тоотны үнэнд 22.0 мянган төгрөг, томилолтын зардалд 242.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн ангилал ашиглах заавар”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн “Заавар батлах тухай” А/170 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 190, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалуудыг хэрэгжүүлж, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

5.3.2. Нөхөн хангалтын зардлаас ширээ, сандал авахад 400.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар 4 дүгээр тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх заавар аргачлал"-ын 1.1 дэх заалтыг зөрчсөн байна

Өгсөн зөвлөмж: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалуудыг хэрэгжүүлж, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/									
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн
Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын хэлтэст 563.7 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн боловч өр төлбөрөөр тусгаагүй, ХХОАТ-ын өглөгийг 8.9 мянган төгрөгөөр дутуу тусгасан байна.	1	572.6	1	572.6			1	572.6		
Дүн	1	572.6	1	572.6	0	0	1	572.6	0	0

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажиллагсдын 2022 оны 7 дугаар сарын цалинг Нийгмийн даатгалын хэлтэст 2,559.6 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.	1	2,559.6			1	2,559.6						
Хичээл практикийн зардлаас шатахууны зардалд 531.8 мянган төгрөг, худдаасан хэвлэлд 158.4 мянган төгрөг, албан тоотны үнэнд 22.0 мянган төгрөг, томилолтын зардалд 242.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	1	954.2					1	954.2				
Нөхөн хангалтын зардлаас ширээ сандал авахад 400.0 мянган төгрөг зарцуулсан байгаа нь	1	400.0					1	400.0				



**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 502,105.9 мянган төгрөгийн 13 гүйлгээ, зарлагын 42,995.7 мянган төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	0	0	0	0	0
Дүн	1	0	0	0	1	0

00000